



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/196

Булган сум

Ой, хээрийн гал түймрийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх байнгын хяналтын цэг ажиллуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 32.1.7, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.7, 17.2.20, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх журам”, Улсын онцгой комиссын даргын 2025 оны “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний удирдамж” 01 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын онцгой комиссын 2025 оны “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 01 дүгээр албан даалгаврын дагуу аймгийн хэмжээнд ой, хээрийн гал түймрийн эрсдэл өндөртэй сумдын нутаг дэвсгэрт ой, хээрийн гал түймрийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх байнгын хяналтын цэгийг 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс 05 дугаар сарын 02-ны өдөр хүртэл ажиллуулсугай.

2. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх байнгын хяналтын цэгийн байршил, зөөврийн сууц, ажиллах хүн хүч, техник, баримт бичиг, заавар зөвлөмжийг бэлтгэн ажиллуулахыг Хангал сумын Засаг дарга (С.Ичинхорлоо), Сэлэнгэ сумын Засаг дарга (А.Ганбагана), Тэшиг сумын Засаг дарга (Б.Гансүх), Хутаг-Өндөр сумын Засаг дарга (О.Далайцэрэн), Бугат сумын Засаг дарга (Х.Ууганбаяр), Орхон сумын Засаг дарга (Х.Ундрахбаяр) нарт тус тус даалгасугай.

3. Байнгын хяналтын цэгийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг Гамшгаас хамгаалах тухай хууль, Ойн тухай хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу холбогдох зардлаас шийдвэрлэж ажиллахыг дээрх сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Онцгой байдлын газар (дэд хурандаа Н.Хишигдорж), Байгаль орчны газар (А.Гантөмөр), Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа Б.Эрдэнэбилэг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Булган Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010284